



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/424

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хөрсний доройтлыг бууруулж, усыг зохистой ашиглах зорилгоор 3 дугаар Ус дулаан дамжуулах төвөөс 7 дугаар цэцэрлэг хүртэлх ДХ143-ДХ129-р худаг чиглэлийн гадна дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамын өргөтгөл, шинэчлэл (Булган сум)-ийн ажлын гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Гуа орд” ХХК-тай 712,652,883 (долоон зуун арван хоёр сая зургаан зуун тавин хоёр мянга найман зуун наян гурав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Гуа орд” ХХК-ийн захирал (Г.Наранбат)-д үүрэг болгосугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010588

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 20-ны/ний өдрийн
А/Ч.2.4 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	12 374 594	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	12 374 594	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	6 187 297	Ү.Бямбасүрэн
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 56 хоног	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Алдангийн хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Э.Эрдэнэжаргал
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Э.Эрдэнэжаргал Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Э.Эрдэнэжаргал

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Sugar Ажил 2025 өдөр бүр Дос/2025/Захирамж